



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.08.24 № 51

Туулын хурдны замын талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйл, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд энэхүү асуулгыг тавьж байна.

1. “Туулын хурдны зам” төсөлд 2025 онд 401.0 тэрбум, 2026 онд 99.0 тэрбум төгрөг буюу нийт 500.0 тэрбум төгрөгийн урьдчилгаа олгож, Туул голын сав газар дахь мод, бут, сөөгийг огтолж, байгаль орчинд хохирол учруулсан шийдвэрийн хариуцлагыг хэн хүлээх вэ? Энэхүү 500.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт бүрэн буцаан төвлөрүүлж, төсөв болон байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэн, улсыг хохиролгүй болгох талаар Монгол Улсын Засгийн газар ямар арга хэмжээ авч, хэзээ хэрэгжүүлэх вэ?

2. Дээрх урьдчилгааг нарийвчилсан ажлын төлөвлөгөө, тоо хэмжээ, гүйцэтгэлийн хуваарьгүйгээр олгосон төдийгүй гүйцэтгэгчийн тайлагнасан 350.9 тэрбум төгрөгийн зарцуулалт нь дансны үлдэгдэлтэй зөрсөн, анхан шатны баримт ирүүлээгүйгээс Үндэсний аудитын байгууллага зарцуулалтыг баталгаажуулж чадаагүй байна. Иймд урьдчилгааны зарцуулалт, өнөөгийн үлдэгдэл, бодит гүйцэтгэл, тайлангийн зөрүүг шалгаж тулгасан тоо, баримтыг ирүүлнэ үү. Баталгаажаагүй зарцуулалт болон учирсан хохирлыг хэнээр нөхөн төлүүлэх, шийдвэр гаргасан болон хэрэгжүүлсэн албан тушаалтан, гүйцэтгэгчид ямар хариуцлага хэзээ тооцох вэ?

3. 2025 оны 08 дугаар сарын 05-нд “Хятадын ХаоЮань групп” болон “Тяньжин Өүбайвэй”-тэй байгуулсан НХААГ/20250101139 дугаартай, 2.345 их наяд төгрөгийн гэрээг төсөл эхлүүлэх эрх, бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлтгүй үед байгуулсан, тендерийн хугацаа, үнийн нөхцөл болон FIDIC-ийн нөхцөл зөрүүтэй, гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлтэй гэсэн аудитын дүгнэлтэд Засгийн газар ямар хариулт өгөх вэ? Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва 2026 оны 08 дугаар сарын 21-ний өдөр UNCCD COP17-ын хүрээнд зохион байгуулсан “Хотын дарга нарын чуулга уулзалт”-ын үеэр “Туулын хурдны зам гэсэн ойлголт байхгүй болсон. Хуучин трассаар энэ зам хийгдэхгүй. ...Өөр зам хийхээр хэлэлцэж, төлөвлөж байна.” гэж мэдэгдсэн. Ийм ноцтой зөрчилтэй гэрээг цуцалж, хуулийн дагуу дахин сонгон шалгаруулалт явуулахын оронд дээрх компаниудтай өөр трассаар, өөр төсөл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь хууль зүйн болон эдийн засгийн хувьд үндэслэлтэй гэж үзэж байгаа эсэх, хэрэв үргэлжлүүлэх бол ямар эрх зүйн акт, судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэж байгааг тодорхой тайлбарлана уу.

4. “Туулын хурдны зам” төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш ТЭЗҮ, зураг төсөл, БОННУ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, газар чөлөөлөлт, зөвлөх үйлчилгээ болон бусад суурь судалгаа, бэлтгэл ажилд зарцуулсан төсвийн нийт дүнг ажил, гэрээ тус бүрээр нь задалж

ирүүлнэ үү. “Туулын хурдны зам” төсөлд зарцуулсан уг хөрөнгийн хэдийг нь төсөвт буцаан төвлөрүүлэх, үр ашиггүй зардал, учирсан хохирлыг хэнээр нөхөн төлүүлж, холбогдох албан тушаалтнуудад ямар хариуцлага тооцох вэ?

5. Шалгалтаар төслийн ажлын зургийг 2026 оны 03 дугаар сарын 13-нд баталж, зам барилгын ажлын зөвшөөрлийг 3 дугаар сарын 15-нд олгосны дараа Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 03 дугаар сарын 19-нд, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 4 дүгээр сарын 17-нд баталсан, мөн археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгаа болон шаардлагатай зөвшөөрлүүд бүрдээгүй байсан нь тогтоогдсон. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, магадлал, ус үер, хөрс ургамал, ойн сан, археологи, палеонтологи, угсаатны зүйн зэрэг суурь судалгаа бүрэн хийгдээгүй байхад зөвшөөрлийн дараалал зөрчиж ажил эхлүүлсэн, шийдвэр гаргасан болон хэрэгжүүлсэн албан тушаалтнуудын нэр, албан тушаал, гаргасан шийдвэрийн огноо, дугаар, эрх зүйн үндэслэл болон тухайн албан тушаалтнуудад ямар хариуцлага тооцсон эсхүл тооцох талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

6. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Б.Пүрэвдагва 2026 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Туулын хурдны замын бүтээн байгуулалт болон нийслэлийн бусад асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөхдөө “Туулын хурдны замын асуудал Арбитрын шүүхэд шилжиж бид зам ч үгүй, мөнгө ч үгүй болох эрсдэлтэй байсан. Нийслэлээс гүйцэтгэгч компанитай хийсэн хэлэлцээрийн үр дүнд тэр аюул байхгүй болсон. Шүүхийн процесс дуусахыг хүлээж байна...” гэж мэдэгдсэн. Энэхүү мэдэгдлийн хууль зүйн үндэслэл юу вэ? Гэрээний маргаан шийдвэрлэх зохицуулалт, холбогдох хууль, дүрэм, гүйцэтгэгчээс ирүүлсэн мэдэгдэл ба төлбөрийн шаардлага, мөн гэрээ, гүйцэтгэсэн ажлын төлбөр, алдагдсан ашиг, болзошгүй торгууль, нөхөн төлбөрийн тооцооллыг гаргаж, Монгол Улсыг эрсдэлд оруулах гэрээ байгуулсан, уг үйлдэлдээ хариуцлага хүлээвэл зохих албан тушаалтныг нэрлэнэ үү.

7. Төр бүсээ чангалж, төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг танаж байгаа энэ үед ТЭЗҮ болон холбогдох нөхцөл нь өөрчлөгдсөн, эдийн засгийн үр ашиг нь тодорхойгүй, улсад аль хэдийн хохирол учруулаад байгаа мега нэртэй төсөлд хөрөнгө оруулах нь зөв шийдвэр эсэх тал дээр Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд Та ямар итгэл үнэмшил, байр суурьтай байгаа вэ? Засгийн газар “Туулын хурдны зам” төслийг одоогийн хэлбэрээр үргэлжлүүлэх, зогсоох, цуцлах, эсхүл шинэчлэн төлөвлөж хэрэгжүүлэхийн аль хувилбарыг сонгож байгаа вэ? Уг сонголтын хууль эрх зүй, эдийн засгийн үндэслэл, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, эдийн засгийн үр өгөөжийн тооцоог ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлмэгц мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЖАРГАЛАН

2026000149